



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2019 оны 11 сарын 19 өдөр

Дугаар 475

Улаанбаатар хот

**Дуудлагын худалдааг дахин зохион
байгуулах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 44 дүгээр зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 2019 оны 268 дугаар тогтоолын 4.4, "Мэдээ, тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаагаар оролцогч ирээгүй, элэгдлээрээ өртгөө нөхсөн, нийт 15,384,600.00 (арван таван сая гурван зуун наян дөрвөн мянга зургаан зуун) төгрөгийн балансын үнэ бүхий автомашины нээлттэй дуудлагын худалдааг (3 дахь) дахин зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн захирал Л.Баттөрд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан мэдээ, тайлангийн баталсан маягтын хамт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0000959



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 1 дүгээр сарын 13 ний өдрийн
475 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ХААГЧДЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ДАХИН ХУДАЛДАХ АВТОМАШИН

Д/д	Автомашинны нэр, улсын бүртгэл, арлын, хөдөлгүүрийн дугаар	Ашиглалтад орсон огноо	Нийт гүйлт (км)	Балансын үнэ (төгрөг)	Хуриимтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	ТӨБЗГ-ын 2019 оны 336 дугаар тогтоолоор тогтоосон доод үнэ (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1	Соната-5, 73-10 УБА (арал-кмher41br3a908580)	1/1/2007	194214	15,384,600.00	15,384,600.00	-	1,000,000.00	500,000.00
	Нийт дүн			15,384,600.00 (арван таван сая гурван зуун наян дөрвөн мянга зургаан зуун)			1,000,000.00 (нэг сая)	500,000.00 (таван зуун мянган)